

НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6-Р ХОРОО, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮСЭД ХЭРЭГЖИЖ БУЙ
“МИНЖИМ” ХХК-ИЙН “ЗААН ТЭРЭЛЖ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЦОГЦОЛБОР ТӨСЛИЙН 2026 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2026

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.3. Төслийн байршил.....	3
1.4. Төслийн хүчин чадал.....	3
1.5. Төслийн барилга, байгууламж, төлөвлөлт.....	3
1.6. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил.....	4
1.6.1. Унд ахуйн усны хэрэглээ	5
1.7. Гарах хаягдал, ялгарал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам	7
1.7.1. Хатуу хог хаягдал	7
1.7.2. Шингэн хаягдал.....	7
1.7.3. Хийн хаягдал	8
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	9
2.1. Төслийн нөлөөллийн тодорхойлолт.....	9
2.2. Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох, үнэлэх	10
2.2.1. Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлох.....	10
2.2.2. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл	13
3. 2026 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
7. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
12. ДҮГНЭЛТ.....	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Унд ахуйн ус хэрэглээний тооцоо	6
Хүснэгт. 2 Ногоон байгууламжийн усалгааны тооцоо.....	6
Хүснэгт 3. Ахуйн хатуу хог хаягдлын тооцоо	7
Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийн магадлан жагсаалт	11
Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ.....	13
Хүснэгт 6. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр.....	14
Хүснэгт 7. Ногоон байгууламж байгуулахад шаардагдах зардал	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	3
Зураг 2. Төслийн талбайн дотоод зохион байгуулалтын зураг	4
Зураг 3. Төслийн талбайн орчны зураг	5
Зураг 4. Бохир ус зайлуулж буй схем бүдүүвч болон төслийн бохирын цооног.....	8
Зураг 5. Төслийн нөлөөллийн бүс	9
Зураг 6. Орчны хяналт шинжилгээний цэг.....	17

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Минжим” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011019146

Регистрийн дугаар: 2585758


Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 0000276

Холбоо барих утас: 99103324

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, элистей, 546, 1003 тоот.

1.3. Төслийн байршил

“Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төсөл нь Нийслэлийн Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд 10.0 га талбайд хэрэгжиж байна.




Зураг 1. Төслийн талбайн байршил

1.4. Төслийн хүчин чадал

“Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор нь бүрэн хүчин чадлаараа ажиллахад нэг ээлжиндээ 200-310 амрагч, 10 үндсэн ажилчинтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Төслийн хувьд хэрэглээний усаа төслийн талбайд гаргасан гүний худгаас хангадаг

1.5. Төслийн барилга, байгууламж, төлөвлөлт

“Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” хүүхэд, залууст зориулсан спорт аялал жуулчлалын цогцолбор нь дараах барилга, байгууламжаас бүрдэнэ. Үүнд:



Зураг 2. Төслийн талбайн дотоод зохион байгуулалтын зураг

- Менежерийн байр: 2 давхар, тоосгон (8X8м хэмжээтэй), доороо гражтай 96 м.кв
- Амрагчдын байр: Тах хэлбэртэй, 1 давхар тоосгон, (102X21м хэмжээтэй) 21 өрөөтэй 650 м.кв
- Рестораны барилга: 18.7X12.5м хэмжээтэй, урдаа 18X8М үйлчилгээний задгай хагас дугуй тавцантай 234 м.кв
- Ажилчдын байр: 1 давхар тоосгон, (20X6м хэмжээтэй) 4 өрөө, дотор засал дутуу 120 м.кв
- Гэрийн буурь: 7 метрийн диаметртэй, бетондсон 16ш буурь, урдаа 2X2м тавцантай, бүгдэд нь цахилгааны холболт хийсэн.
- Ресейпшний барилга: 1 давхар тоосгон барилга (16X6м)

Спорт талбайнууд

- Хөл бөмбөгийн 45X90м-н стандарт талбай болон хөнгөн атлетикийн талбайг хүрээлэн бетондож, нийтэд нь тэгшлэн нэг удаа Канад зүлэгний үр тарьсан
- Сагсан бөмбөгийн 2ш стандарт талбайг бетондож, тэмдэглэгээ хийж, шийд цагаригуудыг суулгаж бэлэн болгосон.
- Элсэн волейболын 2ш талбайтай

1.6. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Төслийн талбай орчинд зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, цахилгаан хангамж зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн.

Цахилгаан хангамж: Төвийн эрчим хүчнээс хангаж байна.

Цэвэр усны хангамж: Төслийн талбайд байрлах гүний худгаас усны хэрэгцээг хангаж байна.

Харилцаа холбоо: Холбоо мэдээллийн хувьд бүх үүрэн телефон холбоо ашиглах боломжтой. Гар утасны сүлжээ, интернэтэд бүрэн холбогдсон байна.



Зураг 3. Төслийн талбайн орчны зураг

Зам харилцаа: Улаанбаатар-Тэрэлжийн хатуу хучилттай зам дагуу байршиж байна.

Дулаан хангамж: Төслийн дулаан хангамжийг цахилгаан болон уурын зуух ашиглан хосолсон байдлаар хангадаг.

1.6.1. Унд ахуйн усны хэрэглээ

“Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор нь бүрэн хүчин чадлаараа ажиллахад нэг ээлжиндээ 200-310 амрагч, 10 үндсэн ажилчинтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Төслийн хувьд хэрэглээний усаа төслийн талбайд гаргасан гүний худгаас хангадаг бөгөөд төслийн цэвэр усны хэрэглээг тооцвол дараах тооцоо гарч байна.

Усны хэрэглээг тооцохдоо БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан **“Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”**-ыг баримтлав. Нэг хүний өдөрт хэрэглэх усны нормыг 200.0 л гэж тооцсон бөгөөд энд тус нормын 14 дүгээр хавсралтыг үндэслэн тооцов.

Хүснэгт 1. Унд ахуйн ус хэрэглээний тооцоо

Унд ахуйн усны хэрэглээ						
Хүчин чадал (хүн)		Норм, л	Хоногт, л	Сард, м ³	Төсөл хэрэгжих нэг жилд, м ³	
Амрагчид	Байшин	240	200	48000	1440м ³	14400 м ³
	Гэр	70	200	1400	420м ³	4200 м ³
Ажилчид		10	200	2000	60м ³	600 м ³
Нийт		-	64000	1920	19200	

1 сарыг 30 хоног, 1 жилийг 300 хонгоор тооцов.

Унд ахуйн нийт усны хэрэглээ:

Усны нөөцөд учруулах эрсдэлийг тооцож төслийн бүрэн хүчин чадлаар усны хэрэглээг тооцоолбол тус төсөл нь хоногт 64.0 м³, сард 1920.0 м³, төсөл хэрэгжих талбайн жилийн нийт усны хэрэглээ **19200.0 м³** байна. “Минжим” ХХК-ын хэрэгжүүлж буй “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төслийн усны хэрэглээг төслийн талбай дахь 40м гүн, 1.2 л/с буюу 103.68м³/хон ундаргатай худгаас хангадаг болно. Худгийн ундаргын **61.7%**-тай тэнцэж байна.

Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа:

Нийт 15.0 га талбайд 5700 ш бургас, шинэс, хус, хайлаас тариалан арчлах шаардлагатай. Усалгааг газрын гадаргын налуу, хэлбэржилт, байрлал, цаг уурын нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хийх ба ялангуяа эхний жилд хөрсний чийгийн горимыг барихын тулд 7 хоногт 1 удаа, сард 4 удаа, жилд 12 удаа усалгааг хийнэ. Ногоон байгууламжийн усалгаанд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 11 дугаар хавсралтын дагуу хөнгөн шавранцар хөрсөнд навчит модыг 35 л/мод нормоор тооцоход:

- 1 хоногт 800 ш мод/хон*35л= 1 л буюу 32.0 м³ ус
- 1 сард 28.0 м³/хон*4 удаа=128.0 м³ ус
- 1 жилд 28.0/хон*20 удаа=640.0 м³ ус

Хүснэгт. 2 Ногоон байгууламжийн усалгааны тооцоо

Мод тарималжуулахад зарцуулах усны хэмжээ						
Модны төрөл	Модны тоо ширхэг	Хөрсний шинж чанар	Усалгааны Норм 1ш мод/л	Хоногт /л/	Сард, м ³	Жилд, м ³
Бургас	200	Хөнгөн шавранцар	40	8,000	32.0	96,000
Шинэс	200		40	8,000	32.0	96,000
Хус	200		40	8,000	32.0	96,000
Хайлаас	200		40	8,000	32.0	96,000
Нийт	800		40,0	32,000	128,0	640,0

Төсөл хэрэгжүүлэгч нь нийт 10.0 га талбайд 20%-ийг ургамалжуулалт хийх бөгөөд МНС 5918:2008 стандартад заасны дагуу ойт хээрийн бүсэд нөхөн сэргээлтийн зорилгоор эгнээ хоорондын зайг 5 м, мод хоорондын зайг 5 м байхаар тооцож, 0.2 га (20,017 м²) талбайд нийт 800 ширхэг суулгац тарьж ургамалжуулах шаардлагатай байна.

Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд хоногт 32.0 м³, сард 128.0 м³, жилд нийт 640.0 м³ ус шаардлагатай. Усалгааны ажлыг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байдлаар зохион байгуулах үүднээс БОННУ-ний тайлангийн зөвлөмжийг баримтлан, төслийн хүрээнд ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж барьж, түүнээс гарсан саарал усыг боловсруулан ногоон байгууламжийг услахад ашиглахыг зөвлөж байна. Ийнхүү дахин боловсруулсан усыг ашигласнаар цэвэр усны хэрэглээ мэдэгдэхүйц буурч, усны нөөцийг зүй зохистой ашиглах, тогтвортой менежментэд үнэтэй хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ.

Нийт ус хэрэглээ

- Ажилчид амрагчдын унд-ахуйн усанд: $320 \text{ хүн} * 200 \text{ л/хон} = 64.0 \text{ м}^3/\text{хон}$ (1920.0 м³/сар, 19200.0 м³/жил)
- Ногоон байгууламжийн усалгаанд: $800 \text{ ш мод} * 40 \text{ л} = 32.0 \text{ м}^3/\text{хон}$ (128.0 м³/сар, 640.0 м³/жил)

Нийт 96.0 м³/хон (2048.0 м³/сар, 19840.0 м³/жил) ус шаардагдана.

“Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төслийн усны хэрэглээгээ төслийн унд ахуйн болон ногоон байгууламжийн усны жилийн хэрэглээнд жилд 19840.0 м³ ус ашиглах бөгөөд хоногт 96.0 м³ ус ашиглах бөгөөд ус төслийн талбай дахь 40м гүн, 1.2 л/с буюу 103.68 м³/хон ундаргатай хурдаас хангадаг болно. Хурдгийн ундаргын **92.5%**-тай тэнцэж байна.

1.7. Гарах хаягдал, ялгарал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам

Тус баазаас гарах хог хаягдлыг төлөв байдлаар нь хатуу, шингэн, хийн хаягдал гэж ангилав.

1.7.1. Хатуу хог хаягдал**Ахуйн шинжтэй хатуу хог хаягдал:**

“Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор баазын үйл ажиллагаанаас өдөр тутмын хэрэглээтэй холбоотой ахуйн хатуу хог хаягдал үүснэ. Жуулчны баазаас хүнсний зүйлсийн сав, баглаа боодол, ундааны лааз, шил, полэтилен болон холимог хуванцар сав, хоолны үлдэгдэл, бие засах газрын хаягдал зэрэг хатуу хог хаягдлууд гарна.

Бааз бүрэн хүчин чадлаараа ажилласан тохиолдолд хоногт 96 кг, сард 2880 кг, жилд 28.8 тн орчим хатуу хог хаягдал гарахаар байна. Доорх тооцоог хийхдээ 1 хүн өдөрт дунджаар 0.3 кг хатуу хог хаягдал гаргана гэж тооцов. Бүрэн хүчин чадал гэдэгт нийт 320 хүнийг оруулах бөгөөд үүнээс 310 хүн нь амрагч, жуулчид, 10 нь байнгын ажилчид байна.

Хүснэгт 3. Ахуйн хатуу хог хаягдлын тооцоо

Хатуу хог хаягдлын хэмжээ				
Төсөл хэрэгжих үед	Хүчин чадал (хүн)	Хоногт (кг)	Сард (кг)	Жилд (тн)
Нийт	320	96	2880	28.8

1 сарыг 30 хоног, 1 жилийг 300 хоногоор тооцов.

Хатуу хог хаягдлыг зайлуулах:

Ахуйн шинжтэй хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд их хөнөөлтэй. Хатуу хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэрийг хязгаарлах, хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр цуглуулах, хог хаягдлыг богино хугацаанд зайлуулан, орчныг цэвэрлэх зэрэг арга хэмжээ юм.

Тус бааз нь цаашид хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, хатуу хог хаягдлаар орчны хөрс, агаар бохирдохоос сэргийлж, ахуйн хатуу хог хаягдлыг төслийн талбай дахь таглаатай, зориулалтын саванд цуглуулж, сумын холбогдох байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулан цаг тухай бүрд нь хогийн нэгдсэн цэг дээр тээвэрлэн зайлуулах шаардлагатай.

1.7.2. Шингэн хаягдал**Ахуйн шингэн хаягдал:**

Ахуйн шингэн хаягдлын эх үүсвэр нь цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус, хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус болно. Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн хэрэглээний бохир усыг цэвэр усны хэрэглээний 70%-аар тооцвол хоногт 44.8 м³/хон, сард 1344.0 м³, жилд 13440.0 м³ орчим бохир ус гарахаар байна.

Ахуйн шингэн хаягдлыг зайлуулах:

Баазын үйл ажиллагаанаас гарч буй шингэн хаягдлыг хоолойгоор зайлуулж газар доорх тусгайлан бэлтгэж тоногдсон 2 цооногт хадгалах ба ачаалалтай үед бохир ус зайлуулах машинаар 7 хоног бүр соруулан авч хаядаг. Үүнийг дараах бүдүүвчээр үзүүлэв.



Зураг 4. Бохир ус зайлуулж буй схем бүдүүвч болон төслийн бохирын цооног

1.7.3. Хийн хаягдал

Баазын хувьд хийн хаягдал үүсэх эх үүсвэр нь уурын зуух болон ирж үйлчлүүлж буй амрагчдын авто машины хөдөлгүүр дэх түлшний шаталтаас үүсэх хийн хаягдал болно. Амрагчдын авто машинаас үүсэх нөлөөллийг нарийвчлан тооцох боломжгүй хэдий ч тус баазаар хоногт 200-310 амрагч /дунджаар/ үйлчлүүллээ гэж тооцоход 1 автомашинд 4-5 хүн сууна гэж үзвэл хоногт хамгийн ихдээ 80 авто машин ирнэ. Энэ нь төслийн талбай орчмын агаар орчинд хүчтэй сөрөг нөлөө үзүүлэхгүй болно. Бааз нь 1-2 сараас бусад саруудад ажиллах ба усан шүүлтүүртэй уурын зуухаар дулаан хангамжийг шийдсэн тул төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд багагүй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Гэвч автомашины хөдөлгүүрээс үүсэх угаарын хий, хатуу хог хаягдлыг хугацаанд (зуны улиралд) нь зайлуулаагүйгээс болж ялзарч эвгүй үнэр гарах зэргээр тухайн орчинд бага зэргийн агаарын бохирдол үүсч болзошгүй байна.

орчим нь суурьшлын бүсээс харьцангуй алслагдмал газарт хэрэгжиж байна. “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтэн, экспертүүд хээрийн судалгааны ажлыг нөлөөллийн бүсийн дотор хийж гүйцэтгэв /Хээрийн судалгааны үр дүнг тус тайлангийн техникийн бус хураангуй бүлгээс үзнэ үү/.

2.2. Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох, үнэлэх

2.2.1. Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлох

Нөлөөллийн хэлбэр, шууд, шууд бус эсэх, дараалал, буцалттай, буцалтгүй эсэх, хугацаа зэргийг магадлан жагсаах аргыг (checklist) ашиглан тодорхойлов. Р.Мижиддорж нар байгаль орчны үнэлгээнд магадлан жагсаах аргыг ашиглах 2 хувилбарыг нэгтгэсэн байдлаар боловсруулсан байдаг /Р. Мижиддорж, 2002 он/. Үүнд:

А. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал. Энд байгаль экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудал, бусад асуудал гэсэн хэсэг бүрт хамаарах нөлөөллийн хэлбэр (шууд, шууд бус), хугацаа (богино болон урт хугацааны), нөлөөллийн эрчим (хүчтэй, дунд зэрэг, бага)-ийг харуулсан магадлах жагсаалтыг нэрлэж болно.

Б. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой нөлөөллийн магадлан жагсаалт. Үүнд: Төслийн байршил, уг төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой нөлөөлөл, мөн барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал, төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуур буюу бодлогын чанартай асуудалд хамаарах үйлдвэр аж ахуйн газрын нөлөөллийн эрчмийг заасан байдаг.

А. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал

Байгаль экосистемийн өөрчлөлт: Жуулчны бааз орчимд гадаргын томоохон урсац байхгүй бөгөөд гадаргын усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл нь шууд бус шинжтэй байна. Жуулчны баазын үйл ажиллагаагаар хүн, машин техникийн хөдөлгөөн ихсэх зэргээс эдэлбэр газар болон түүний ойролцоох хөрс, ургамалд шууд нөлөөлнө. Энэ нь зам талбайн тэмдэг тэмдэгжүүлэлт хангалтгүй, машин техникийн нөлөөгөөр ургамлан бүрхэвч талхлагдах зэрэг болно. Төслийн талбай нь төв зам дагуу байрлана.

Авто тээврийн хэрэгслийг тогтсон нэг замаар зорчуулах, тэмдэг тэмдэгжүүлэлтийг стандартын дагуу байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх нь зүйтэй. Мөн тус жуулчны бааз болон тухайн орчинд хэрэгжиж буй бусад төсөл, амрагч жуулчид, дайран өнгөрөх хүн, машин техникийн нөлөөллөөс амьтдын орон зайн өөрчлөлт гарах магадлал бий.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Жуулчны бааз нь үйлчилгээний салбарт хамаарагдаж, амралт, аяллын үндсэн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд олборлох болон уул, газар шорооны ямар нэгэн ажил, үйлдвэрлэл эрхлэхгүй тул байгалийн нөөц, баялагт шууд хүчтэй нөлөөлөлгүй.

Жижиг хэмжээний барилга, байгууламж зэргийг барихад хөрс тэр хэмжээгээр дарагдана. Төсөл хэрэгжих явцад унд ахуйн усны хэрэглээг зөврөөр хангана. Төслийн эдэлбэр газрын хэмжээтэй тэнцэх бэлчээрийн талбай төдий хэмжээнд багасна. Тухайн жуулчны баазын эзэмшлийн газар болон ойр орчимд нь хөрс, ургамал хамгаалах нөхөн сэргээх талаар шат дараалсан, бодитой арга хэмжээ аваагүй нөхцөлд ургамлын төрөл зүйлд өөрчлөлт орж байгалийн унаган төрхөө алдах, цаашлаад устах аюултай. Жуулчны бааз нь ойн захад ойр хэрэгжих тул энэ хүрээнд ойн биологийн олон янз байдал, ойн нөөцөд сөрөг нөлөөлөлгүй үйл ажиллагаа явуулах шаардлагатай.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Бохир ус хуримтлуулах цооног, дамжуулах шугам хоолойд гэмтэл гарах, хатуу хог хаягдлыг удаан хугацааны турш хадгалснаас болж эвгүй үнэр гарах, хүчин чадлаасаа давсан үйл ажиллагаа явуулж хүн, тээврийн хэрэгслийн хөл хөдөлгөөн ихсэх, дуу чимээ ихсэх, орчны цэвэрлэгээ байнга хийгээгүй зэргээс агаар, хөрс, усан орчин бохирдох бөгөөд үүний улмаас ургамлын төрөл зүйл өөрчлөгдөх ан, амьтан үргэх гэх мэт сөрөг нөлөөлөл гарч болзошгүй. Эдгээр нөлөөллүүд нь бага эрчимтэй бөгөөд гадаргын усны бохирдол болон газрын доорх усны бохирдлоос бусад нь шууд нөлөөлөлтэй байна.

Аялал жуулчлалын баазын олон жилийн ашиглалт, байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн улмаас хөрсний бохирдол үүсэх, ургамлан нөмрөг талхлагдах, цаашлаад байгалийн сэргэлт, нөхөн төлжилт, өөрөө өөрийгөө цэвэрлэх чадамж буурах магадлалтай.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, археологи, палеонтологийн олдвор: Жуулчны бааз нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд байрлана. Амрагч жуулчид, ажилчдад байгаль хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар танилцуулга сурталчилгаа хийгээгүй, анхааруулах самбар, тэмдэг хангалтгүй нөхцөлд төсөл хэрэгжиж буй Горхи-Тэрэлж байгалийн цогцолборт газрын байгалийн унаган төрх нь алдагдах, ургамлын төрөл зүйлд бага зэргийн өөрчлөлт орох гэх мэт бага эрчимтэй сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд энэ нь шууд нөлөөлөлд хамаарна. Жуулчны баазын үйл ажиллагаанаас түүх соёлын дурсгалт зүйл археологи, палеонтологийн олдвор зэрэгт ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй болно.

Эдийн засаг, нийгмийн асуудал: Төсөл хэрэгжсэнээр төсвийн орлого, ажлын байр нэмэгдэж ядуурлыг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэхэд түлхэц болсноор эдийн засаг-нийгмийн хувьд урт хугацааны, шууд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн тухайн орчны малчдын морь мал, сүү цагаан идээ, гар урлалын бүтээгдэхүүн зэрэг нь эдийн засгийн эргэлтэд ороход дэмжлэг болох боломжтой.

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийн магадлан жагсаалт

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн хэлбэр			Үргэлж-лэх хугацаа		Нөлөөл-лийн чиглэл		Нөлөөллийн эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө	Богино хугацааны	Урт хугацааны	Буцалттай нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгаль экосистемийн өөрчлөлт											
1	Газрын доорх усны нөөц хомсдох										
2	Гадаргын усны урсац өөрчлөгдөх										
3	Ургамлын нөмрөг өөрчлөгдөх	x			x		x			x	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x	x			x	
5	Геологийн тогтоц өөрчлөгдөх										
6	Геоморфологийн нөхцөлд өөрчлөлт орох										
7	Амьтдын орон зайн өөрчлөлт гарах	x			x		x				x
8	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x		x		x			x
Байгалийн баялаг, нөөц ашиглалт											
1	Ашигт малтмалын нөөц баялаг хомсдох										
2	Эрдэс, түүхий эдийн нөөц хомсдох		x			x		x			x
3	Бэлчээрийн талбай хомсдох	x				x	x				x

4	Ургамлын нөөцөд нөлөөлөх	x				x	x				x
5	Ойн нөөцөд нөлөөлөх	x				x	x				x
6	Ус намгархаг газарт нөлөөлөх										
7	Биологийн олон янз байдалд нөлөөлөх	x				x	x				x
8	Эрчим хүчний нөөц	x				x	x				x
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
1	Газрын доорх усны чанар		x			x			x		x
2	Гадаргын усны чанар										
3	Агаарын бохирдлын бага зэргийн тухайлсан эх үүсвэр бий болох	x			x			x			x
4	Хөрсний бохирдол	x				x	x				x
5	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x			x			x
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
1	Байгалийн унаган төрх өөрчлөгдөх	x				x			x		x
2	Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	x				x			x		x
3	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x				x	x			x	
4	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
5	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
Эдийн засаг, нийгмийн асуудал											
1	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+				+	+				+
2	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+	+				+
3	Ажлын байр нэмэгдэх	+				+	+				+
4	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+				+
5	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	+				+	+				+
6	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+	+				+
Бусад нөлөөлөл											
1	Химийн бодисын нөлөөлөл										
2	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих /Үнэрийн бохирдол	x			x			x			x
3	Төслийн үйл ажиллагаа, хүчтэй салхи шуурга, түймэр, газар хөдлөлт, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн аюул, осол гарах	x			x			x		x	
Дүн = 35		17/5	2/1	1	6/1	14/5	14/6	6	1	3	16/6
Хувь = 100%		62.9	8.6	2.9	30.0	54.2	57.1	17.1	2.9	8.6	62.9

Тайлбар: (x) - сөрөг нөлөөлөл

(+) - эерэг нөлөөлөл

Хүснэгтээс үзвэл байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт тоо 35 байна. Эдгээрийг тодруулж авч үзвэл:

Нөлөөллийн хэлбэр

Шууд нөлөөлөл - Жуулчны баазын үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй шууд нөлөөлөл 22 /62.9%/ байна. Шууд нөлөөллөөс 17 /77.3%/ нөлөөлөл сөрөг, 5 /22.7%/ нөлөөлөл эергээр нөлөөлнө. Төслийн үйл ажиллагааны явцад газрын доорх ус, ургамлан нөмрөг, хөрс, агаар, амьтан зэрэгт шууд сөргөөр нөлөөлөх талтай бол орон нутгийн нийгэм, эдийн засагт шууд эергээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл - Үүнд 3 /8.6%/ төрлийн нөлөөлөл багтаж байна. Шууд бус нөлөөллөөс 2 /66.7%/ сөрөг, 1 /33.3%/ нөлөөлөл эергээр нөлөөлнө. Үүнд, эрдэс, түүхий эдийн нөөц хомсдох, газрын доорх усны чанар өөрчлөгдөх зэрэг нь шууд бус сөрөг нөлөөллүүд бол төсөл хэрэгжсэнээр ядуурлыг бууруулахад шууд бус эерэг нөлөө гарна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Болзошгүй нөлөөллийг үргэлжлэх хугацаагаар нь авч үзвэл богино хугацааны нөлөөлөл 7 /30.0%/, урт хугацааны нөлөөлөл 19 /54.2%/ байна. Нөлөөллийн ихэнх нь урт хугацааны

нөлөөлөл байгаа нь төслийн хэрэгжүүлэх хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатайг харуулж байна.

Нөлөөллийн чиглэл

Энэ хүрээнд нийт болзошгүй нөлөөллийг “буцалттай нөлөөлөх” болон “буцалтгүй нөлөөлөх” гэж 2 хэсэгт хувааж үзэв. Жуулчны баазын үйл ажиллагаанаас 20 /57.1%/ нөлөөлөл буцалттай буюу үр дагавар нь ирээдүйд арилах боломжтой нөлөөлөл байна. Нөгөө талаар энэ нь төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллүүд байгалийн нөхөн сэргэх боломжид сөрөг нөлөөлөл үзүүлэх нь бага байгааг харуулж байна. Харин нийт нөлөөллийн 6 /17.1%/ нь буцалтгүй нөлөөлөл байгаа буюу тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хэвээндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнд сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Нөлөөллийн эрчим

Төслийн сөрөг нөлөөллийн эрчмийг тодорхойлсон хэсгээс үзэхэд нийт 35 нөлөөллөөс 1 нөлөөлөл хүчтэй, 8.6% буюу 3 нөлөөлөл дунд зэрэг, 62.9% буюу 22 нөлөөлөл бага зэрэг эрчимтэйгээр нөлөөлж байна. Төслөөс нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх бол хүчтэй, дунд зэрэг эрчимтэй, сөрөг нөлөөллүүдийг онцгойлон анхаарч, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ажлыг хэрэгжүүлснээр сөрөг нөлөөллийн эрчмийг бууруулах, нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

2.2.2. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл

“Минжим” ХХК-ын хэрэгжүүлж буй “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 28 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлноос байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нөлөөллийн 10.0% нь нөлөөлөлгүй, 40.0% нь бага, 43.0% нь дунд, 4.0% их байна. Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөрөг, амьтан болон газар, газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг					Үнэлгээ	
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Сүйрлийн	Тоо	Хувь
1	Эдэлбэр газарт үзүүлэх нөлөө	3	2	0	0	0	5	18.0
2	Агаарын чанарт үзүүлэх нөлөө	0	3	2	0	0	5	18.0
3	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөө	0	2	4	1	0	7	25.0
4	Хөрсөн бүрхэвч, эдэлбэр газарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	0	1	4	1	0	6	22.0
5	Ургамал, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө	0	1	1	0	0	2	7.0
6	Амьтны аймагт үзүүлэх нөлөө	0	2	1	0	0	3	10.0
Нөлөөллийн эрчим		3	11	12	2	0	28	100.0
		10.0	40.0	43.0	7.0	0.0	100.0	

Төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл:

“Минжим” ХХК-ын хэрэгжүүлж буй “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл тус аялал жуулчлалын цогцолбор төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

Хүснэгт 6. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
<i>Агаар орчин</i>			
1	Тоосжилт	- Хүмүүсийн хөл - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	- Улирлын чанартай. - Тархах хүрээ хязгаарлагдмал. - Амархан сарнина.
2	Утаа, Угаар	- Уурын зуух - Тээврийн хэрэгсэл	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал.
<i>Усан орчин</i>			
3	Хатуу болон шингэн хаягдал	- Ахуйн хог хаягдал - Шатах тослох материалын хаягдал	- Гадаргын ус бохирдоно. - Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. - Удаан сарнина.
4	Усны нөөцийн хомсдол	- Унд ахуйн усны хэрэглээ	- Шууд бус дам нөлөө үзүүлнэ
<i>Хөрсөн бүрхэвч</i>			
5	Элэгдэл, эвдрэл	- Зориулалтын бус замаар явснаар явган жим, зам гарах, хөрс дагтарших, талхлагдах	- Тархалтын хүрээ хязгаарлагдмал. - Тархалтыг хязгаарлах боломжтой. - Нөхөн сэргээх боломжтой. - Шинж чанар өөрчлөгдөнө.
6	Бохирдол	- Ахуйн, шингэн хог хаягдал - Шатах тослох материалын асгаралт - Бохир ус дамжуулах шугам хоолойн гэмтэл, доголдол	- Тархах хүрээ хязгаарлагдмал. - Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана.
<i>Ургамал бүрхэвч</i>			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	- Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зам, жим - Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчимд	- Хэмжээ хязгаарлагдмал. - Тухайн орчны ургамлан нөмрөг багасах, төрөл зүйл хомсдож болно. - Ургамалжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.
8	Бохирдол	- Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал	- Ургамлын биомассын хэмжээ багасна. - Ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж болзошгүй.
<i>Амьтан</i>			
9	Үргэн, дайжих	- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн - Дуу чимээ	Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
10	Бохирдол	- Хог хаягдал - Шатах тослох материалын асгаралт	- Тархалтын хүрээ хязгаарлагдмал - Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой үрэгдэж болно. - Ашиггүй бичил биетэн үржих.
<i>Нийгэм-эдийн засгийн орчин</i>			
11	Амрагч, сувилуулагчдын алжаалыг тайлах	- Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ.	Хүн амын эрүүл мэндэд эерэг нөлөө их.
12	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	Улсын төсөвт хувь нэмэр оруулна.

13	Шинэ ажиллагсад авна.	- Ажлын байр шинээр бий болно.	Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно.
----	-----------------------	--------------------------------	--

Магадлан жагсаах аргаар тооцсон дүн

Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон дүнгээс үзэхэд тус төсөл нь байгаль орчинд нөлөөлөх байдлаараа “*бага-дунд*” нөлөөлөлтэй байна.

3. 2026 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төсөл нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.


Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтанд хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Минжим” ХХК-ийн аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.



Зураг 6. Орчны хяналт шинжилгээний цэг

Агаар орчин: ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

Усны чанар: Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч: Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал рт, аргачлал
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
Төсөлд ашиглаж байгаа техник тоног төхөөрөмж	Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах			ОХШХ-т тусгагдсан.		Тогтмол	“Агаарын тухай хууль” “Агаар бохирдлын төлбөрийн тухай хууль” MNS 4585:2025
	Уурын зууханд яндангийн утааг цэвэршүүлэх төхөөрөмж уутан шүүлтүүр	Техник, машин механизмын ашиглалт		1,500,000		Нэг удаа	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
Ус хэрэглээ, нөөцийн хомсдол үүсэхээс сэргийлэх	Унд- ахуйн хэрэглээнд ашиглах усанд эрүүл ахуйн шинжилгээг хийлгэх	Усны нөөц хэмнэх		ОХШХ-ийн зардал		Тогтмол	“Усны тухай хууль” “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль” MNS 0899 : 2020 Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага
	Ус ашигласан төлбөрийг төлөх			Худгийн тоолуурын заалтаар төлөх		Тогтмол	
	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах			-		Жилд нэг удаа	
	Стандарт хэмжил зүйн газраар усны тоолуурыг баталгаажуулан гэрчилгээний хугацааг сунгуулах			-		Тоолуурын баталгаажилтын хугацаагаар	
	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тогтмол соруулах			Гэрээнд заасан мөнгөн дүнгээр		Тогтмол	
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ							
Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Эзэмшил газар болон эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайг хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх	Төслийн талбай		-		Тогтмол	Хог хаягдлын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, MNS 5914:2008 Байгаль орчныг хамгаалах тухай хууль MNS 5850:2008 – Хөрс бохирдуулагч бодис,
	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх			Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		Тогтмол	
	Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх,			-		Тогтмол	

	Баазын орчинд байгаа, мод, ногоон байгууламж, цэцгийн мандал, зүлэг зэрэг ногоон байгууламжийг арчилж тордож байх.				элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт дүн			1, 500,000		

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч “Минжим” ХХК нь төслийн талбайд 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын хүрээнд 20 ширхэг суулгац тарьж ургамалжуулах мөн Горхи тэрэлжийн хамгаалалтын захиргаатай хийсэн гэрээний дагуу хашаажуулахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт 7. Ногоон байгууламж байгуулахад шаардагдах зардал

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт	
Орчны тохижилтыг сайжруулан талбайд нийт 20 ширхэг суулгац тариалан тарималжуулах болон Горхи тэрэлжийн хамгаалалтын захиргаатай хийсэн гэрээний дагуу хашаажуулах		Бургас	Ширхэг	5 ш	10,000.0	50,000	Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.	
		Шинэс	Ширхэг	5 ш	15,000.0	75,000		
		Хус	Ширхэг	5 ш	12,000.0	60,000		
		Хайлаас	Ширхэг	5 ш	8,000.0	40,000		
		Нийт			20 ш	225,000		
		Агротехникийн ажиллагаа						500,000
		Хашаажуулах болон бусад зардал						1,675,000
Арчилгаа, тордлогоо	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төслийн талбайд				-		
Нийт: 2,400,000₮								

6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилга, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Ахуйн болон аюултай хог хаягдал	Гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Төслийн талбайд	-	-	1	4,000,000	Нэг удаа
	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах менежментийг сайжруулах, ажилчдад сургалт зохион байгуулах	Ажилчдад	-	-	-	-	Нэг удаа
	“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Ахуйн хуурай хог хаягдал	-	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр.		Гэрээний хугацаагаар	
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх, гэрээ байгуулах		-	-	Тогтмол		
Хог хаягдал хуримтлагдах	Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж байх	Ойр орчмын 50 метр газарт	-	Зардал тусгах шаардлагагүй.		Сар бүр	
	Ил задгай хог хаягдал байлгах аас сэргийлэх, тогтмол хяналт тавих	Төслийн талбайд	-	Зардал тусгах шаардлагагүй.		Тогтмол	
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	-	-	-	200.000	Улирал бүр 1 удаа
Шингэн хаягдал	Ахуйн шингэн хаягдлыг цооногт хуримтлуулж, гэрээний дагуу соруулж зайлуулна	Ахуйн шингэн хог хаягдал	-	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр.		Тогтмол	
Нийт дүн: 4,200.000							

7. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ							
Сөрөг нөлөөллийг арилга, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт ба аргачлал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	Төслийн хүрээнд	Жил бүр	-	“Минжим” ХХК	Эрх бүхий мэргэжлийн байгууллага	БОМТ-ний тайлан	Байгаль хамгаалах тухай хуулийн 10 ¹ Газрын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам Хог хаягдлын тухай хууль Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон бусад
Батлагдсан БОМТ-г бүх шатны ЗД, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, аймгийн БОУАӨЯ-д хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	Жил бүр	-			БОБТ	
Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал	Бүх ажилчид	Жилд 1 удаа	-		Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор	Сургаалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл	
Орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага, хорооны иргэдийн саналыг сонсож, зохих арга хэмжээ авах, харилцан мэдээлэл солилцож байх	Төслийн хүрээнд	Орон нутгийн иргэдийн санал хүсэлт	Тухайн үеийн үйл ажиллагааны зардалд тусгагдана.		-	Хурал уулзалтаас гарсан шийдвэр	
Ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх	Төсөвт хувь нэмэр оруулах	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдана.		-	Төлбөр төлсөн баримт	
Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	Төслийн хүрээнд	Жил бүр	-		Усны газар	Дүгнэлт	
Амралтын газар, жуулчны баазын ойр орчимд байгаль орчинтой холбоотой зүй зохистой харьцах тухай санамжуудыг байршуулах	Төслийн хүрээнд	Нэг удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдана.		БОА	Байршуулсан байдал, т самбар	
Галын дүгнэлт гаргуулах	Төслийн хүрээнд	Дүгнэлтийн хугацаагаар тогтмол	-		-	Дүгнэлт	
Нийт зардал							

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал алдагдах, осолд өртөх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгааг тогтмол хийж байх, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа Бүх ажилчдад	Нийт ажилчдын тоогоор /ш/	ХАБЭА-н зардалд тусгах		Сард нэг удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5080:2023” стандарт
	Баазын ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургаж байх	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	Бүр ажилчдыг хамруулах	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	
	Эмнэлгийн анхан шатны хэрэгслээр тоногдсон ажлын байрны бэлэн байдлыг хангаж, осолд өртсөн ажилтанд анхны тусламж үзүүлэх	Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах	Төслийн талбайд	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5080:2023” стандартыг мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Төслийн хүрээнд	ХАБЭА-н зардалд тусгах		Тогтмол	

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт, хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд, доод хязгаар	Нэгжийн өртөг мян. төг	Нийт зардал, мян.төг
							жил
“Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төслийн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр							
Агаар: Тоос, мкг/м ³ , CO, мкг/м ³ , SO ₂ , мкг/м ³ , NO ₂ , мкг/м ³	Нийт 2 цэгт	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Агаарын тухай хууль, MNS 4585:2025, MNS 4585:2016, MNS 5014 : 2009, Дизель хөдөлгүүртэй автомашин - Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	225.0	450.0
Зуухны хаягдал утаан дахь хийн агууламж (O ₂ , CO, NO, NO ₂ , NO _x , CO ₂ , SO ₂)	Уурын зуух	Жилд 1 удаа	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар	MNS 5919:2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	220.0	220.0
Зуухны хаягдал утаан дахь нийт тоосны агууламж (TSP)	Уурын зуух	Жилд 1 удаа	Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар	утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	150.0	150.0
Дуу чимээ: Хамгийн их түвшин, дБА Хамгийн бага, дБА түвшин Дундаж түвшин, дБА	Нийт 2 цэгт	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Агаарын тухай хууль, MNS 4585:2025 “Агаарын чанарын стандарт. Техникийн шаардлага”	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	50.0	100.0
Унд ахуйн ус: Усны химийн шинжилгээ Био идэвхит нэгдлүүд Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо, Гэдэсний бүлгийн савханцар, Эмгэг төрөгч бактери Cl.perferringens	Гүний худгаас	Жилд 2 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	70.0	140.0
Хөрс: Хөрсний механик бүрэлдэхүүн, физик чанар Агрохимийн чанар Хүнд металл (As, Pb, Zn, Cd, Fe) мг/л	Төслийн талбайн 2 цэгээс	Жилд 2 удаа	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	MNS 5850:2019Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Стандартад заасан хэмжээтэй харьцуулна.	100.0	200.0
“Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төслийн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал						1,260.000	

10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ							
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	
Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	БО-ны мэргэжилтэн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1	Шинжээчдийн дүгнэлт	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа	“Минжим” ХХК	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Сум,баг		
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Байгаль орчны газар		

**11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ						
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Жил бүр 1 удаа	-	-	“Минжим” ХХК
БОУАӨЯ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Тухайн жилийн 11-12 сарын дотор	-	-	

12. ДҮГНЭЛТ

Тус “Минжим” ХХК-ийн “Заан тэрэлж” аялал жуулчлалын цогцолбор төсөл нь Нийслэлийн Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хязгаарлалтын бүсэд 10.0 га талбайд хэрэгжиж байна.

Тус төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2026.03.04-ны өдөр батлагдсан бөгөөд 2026 оны Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **9,360,000** төгрөг зарцуулах урьдчилсан дүн гарсан байна.

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	1,500,000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2,400,000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	4,200,000
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	-
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардалд тусгах
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	1,260,000
Нийт	9,360,000